

ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.

2022.02.09

Онцлох мэдээ

- Япон улсын эдийн засагт эргэлдэж буй мөнгөний хэмжээ 1-р сард өссөнөөр 11 сар дараалан өссөн рекорд тогтоолоо. Тус улсын төв банкны тоон мэдээгээр М3 мөнгөний нийлүүлэлт 1-р сард 3.3% нэмэгдсэн байна. Ингэснээр нийт дүн 1,534.50 их наяд иен (\$13.29 их наяд) буюу Японы эдийн засгийг 3 дахин нэмэгдүүлсэнтэй ижил хэмжээнд хүрэв.
- АНУ-ын бизнесүүд хүчтэй эрэлтийг хангахын тулд бараа материалаа нөөцлөн, импорт огцом нэмэгдсэнээр 2021 онд худалдааны алдагдал нь рекорд дээд түвшинд хүрчээ. 2020 онд 676.7 тэрбум ам.доллар хүрч байсан худалдааны алдагдал нь 2021 онд 27.0% өсөж 859.1 тэрбум ам.доллар буюу бүх цагийн үеийн дээд түвшинд хүрсэн байна.

Валютын зах зээл

Ам.долларын ханш иений эсрэг нэг сарын дээд цэгт хүрч чангарлаа. Арилжаачид АНУ-ын инфляцийн мэдээнээс Холбооны Нөөцийн банкнийг мөнгөний хатуу бодлогоо хэр хурдтай хийх эсэхийг хүлээж буй бөгөөд засгийн бондуудын өгөөж шөнийн дотор хэдэн жилийн оргил цэгт хүрсэн нь ам.долларын ханшинд дэмжлэг болсон байна. Европын төв банк болон ХНБ-ны мөнгөний бодлогоо илүү чангатгах шинж байдал зах зээлийг цочроож, евро бүсэд өгөөжүүдийг огцом өсгөсөн бөгөөд хүүг өмнөхөөс илүү ихээр мөн хурдтай өснө гэсэн хүлээлт үүсгэлээ. Ам.доллар иений эсрэг 115.69 болж 01.10-наас хойших дээд түвшинд хүрэв. Евро Баасан гарагийн 1.1483 түвшнээс аажмаар суларч 1.142-т өөрчлөлт багатай байна.

Алтны зах зээл

Лхагва гарагт алтны ханш өмнөх арилжааны өдөр хүрсэн 2 долоо хоногийн дээд түвшинд тогтворжоод байна. АНУ-ын Төв банк бодлогын хүүгээ хурдацтай өсгөх хүлээлт байгаа хэдий ч инфляцийн эрсдэл ба Орос-Украин хоорондын харилцааны хурцадмал байдал эрсдэл багатай металлын ханшийг барьсаар байна. Унц алтны спот ханш Мягмар гарагийн дээд цэг 1,828.68-тай ойролцоо 1,825.89 ам.доллар дээр тогтворжоод байгаа юм. АНУ-ын алтны фьючерс 0.1% буурч 1,826.30 ам.доллар боллоо.

Зэсийн зах зээл

Ам.долларын ханш суларч, эрсдэл даах чадвар сайжирснаар Лондонд зэсийн үнэ өссөн бол хөнгөн цагааны үнэ 14 жилийн дээд түвшинтэй ойролцоо эргэлдсээр байна. Лондонгийн Металлын Биржийн зэсийн фьючерс 0.3% дээшилж 9,811 ам.долларт, Шанхайн Фьючерсийн биржийн зэс 0.1% буурч тонн нь 70,500 юань (\$11,082.47)-р тус тус арилжаалагдаж байна. ЛМБ, ШФБ болон ЧХБ-үүдийн зэсийн агуулах дахь нөөц 1-р сарын

Валют	Ханш	24ц өөрч.		
EUR/USD	1.1426	0.10%		
USD/CNY	6.366	0.10%		
USD/RUB	75.0133	0.00%		
USD/JPY	115.4	-0.13%		
USD/KRW	1195.55	-0.22%		
AUD/USD	0.7154	-0.05%		
GBP/USD	1.3556	0.00%		
Индекс	Нэгж	24ц өөрч.		
Dow Jones	35462.8	1.06%		
S&P 500	4521.5	0.84%		
NASDAQ	14194.5	1.28%		
FTSE 100	7567.1	-0.08%		
Nikkei 225	27496.9	0.78%		
DAX	15242.4	0.23%		
Hang Seng	24726.9	1.63%		
Метал	Ханш (USD)	24ц өөрч.		
Алт	1827.74	0.10%		
Мөнгө	23.28	0.41%		
Нүүрс (Чин хуанг дао)	165.72	7.98%		
Зэс (LME)	9781	0.04%		
Төмрийн хүдэр	786.50	-5.24%		
Газрын тос (NYME)	89.44	0.09%		
LIBOR	Хүү	24ц өөрч.		
US 1M LIBOR	0.12%	8.17%		
US 3M LIBOR	0.36%	6.91%		
US 6M LIBOR	0.62%	12.09%		
US 12M LIBOR	1.09%	9.28%		
Бонд	Хүү	24ц өөрч.		
US Treasury 10Y	1.94%	-1.30%		
UK Treasury 10Y	1.49%	5.75%		
GE Treasury 10Y	0.27%	16.23%		
JP Treasury 10Y	0.21%	-5.96%		
Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24ц өөрч.
Чингис	5.13%	12/5/2022	3.09%	-0.01%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.71%	-0.03%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	4.03%	0.10%
Хуралдай	8.75%	3/9/2024	4.08%	-0.16%
ММС	9.25%	4/15/2024	22.17%	0.29%
МИК 2024	8.85%	8/2/2024	11.18%	-0.05%
Номад	5.13%	4/7/2026	4.76%	-0.01%
Монгол 27	3.50%	7/7/2027	4.98%	-0.16%
Монгол 31	4.45%	7/7/2031	5.42%	-0.11%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.04%	-0.01%

Хувьцаа	Ханш	24ц өөрч.
Turquoise Hill Resources	19.54	1.93%
Mongolian Mining Corp	1.94	3.74%
Erdene Resource Dev	0.44	14.29%
Centerra Gold	10.67	0.85%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2021 (XII)	13.4%
Бодлогын хүү	2022 (I)	6.5%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (XI)	6.08%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2021 (XII)	7.04%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2021 (XII)	2.04%
Зээлийн дундаж хүү (төг)	2021 (XII)	15.54%
Зээлийн дундаж хүү (валют)	2021 (XII)	9.07%

Ханшийн таамаглал

Валют	Q1 22	Q2 22	Q3 22	Q4 22	2023
EUR/USD	1.12	1.13	1.15	1.15	1.17
GBP/USD	1.34	1.35	1.36	1.37	1.40
USD/CNH	6.39	6.35	6.40	6.44	6.40
USD/JPY	114	115	115	115	115
USD/RUB	73.0	72.0	73.07	73.0	73.5

Түүхий эд

Алт	1775	1750	1700	1680	1650
Зэс	9500	9350	9400	9500	9550
Нүүрс	138.13	109.38	93.13	79.38	62.50

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүмбэрг

Өмнөх өдрийн үр дүн	Үр дүн	Таам.	Өмнөх
CA Trade Balance C\$	-0.14B	2.62B	3.13B
US International Trade \$	-80.7B	-83.0B	-80.2B
JP Current Account NSA JPY	-370.8B	73.5B	897.3B

Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
US Wholesale Invt, R MM	23:00	2.1%	2.1%
GE Trade Balance EUR	15:00	10.4B	10.9B
IT Industrial Output YY	17:00	5.0%	6.3%
IT Industrial Output MM	17:00	-0.7%	1.9%

Маргааш хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
US Initial Jobless Claims	21:30	230k	238k
US CPI MM	21:30	0.5%	0.5%
JP Corp Goods Price YY	7:50	8.2%	8.5%
JP Corp Goods Price MM	7:50	0.4%	-0.2%

эцэст 200,402 тонн байв. Өнгөрсөн жилд 73,000 тонноор буурч 4 жил дараалан буурсан байна.

Газрын тосны зах зээл

АНУ-ын газрын тосны нөөц буурснаар хоёр өдөр унасан газрын тосны ханш эргэн өслөө. Хэдийгээр Иран улс нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүлээлттэй байсан ч АНУ-ын мэдээ ханшинд хүчтэй нөлөөллөө. АНУ-ын нөөц 2 сая баррелиар буурсан нь 400,000 баррелиар өснө гэсэн шинжээчид хүлээлтэд хүрсэнгүй. Brent газрын тосны үнэ 0.3 хувь өсөж 91.01 ам.долларт арилжаалагдаж байна.

Бондын зах зээл

Дэлхийн хамгийн том бондын зах зээлд зарах хөдөлгөөн үргэлжлэх төлөвтэй байгаа бөгөөд бодлогын хүүг эрчтэй өсгөх хүлээлт нэмэгдсээр хөрөнгө оруулагчдын бодлоор энэ нь АНУ-ын 10 жилийн хугацаатай засгийн бондын өгөөжийг 2% давуулах юм байна. 10 жилийн өгөөж 2019 оны 11-р сараас хойших дээд цэг 1.96% Мягмар гарагт хүрээд буцсан. Австралийн голлох өгөөж 13 нэгж нэмэгдсэн бол Японд тус өгөөж нь Төв банкны хамгаалж барина гэсэн түвшиндээ хүрээд байна.

Хөрөнгийн зах зээл

Өнөөдөр хөрөнгийн зах зээл өсөж, бондыг худалдах хөдөлгөөн түр намжаад байна. Япон болон Хонг Конгийн өсөлт Азийн зах зээлд өсөлт үзүүлэхэд жин дарлаа. Өчигдөр АНУ-ын индексүүд өсөлттэй хаагдсан тул Азийн зах зээлд фьючерсүүд мөн өслөө. Хувьцаанууд хангалттай унасан гэж үзсэн хөрөнгө оруулагчид технологи болон бага зах зээлийн үнэлгээтэй компаниудын хувьцааг ихээр худалдан авлаа.

Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдлад ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харуцлага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин ут и-мэйлд харуу илгээнэ үү.